



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/18

Пионер толгой

Мал, амьтны гоц халдварт “Шүлхий”
өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улс, аймгийн хэмжээнд малын гоц халдварт “Шүлхий” өвчний тархалт нэмэгдэж, хөрш зэргэлдээ орших Архангай аймгийн Хангай, Цахир сумууд, Завхан аймгийн Отгон сумд голомтлон дэгдэж байгаатай холбогдуулан Архангай аймгийн Хангай, Цахир, Завхан аймгийн Отгон сум, бусад сэжигтэй болон халдвартай бүсэд зорчихгүй байх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн худалдан авахгүй байхыг нийт малчид, ард иргэдэд зөвлөсүгэй.

2. Малын гоц халдварт Шүлхий” өвчний талаар малчид, ард иргэдэд сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл хүргэх, ухуулга сурталчилгаа хийх зэргээр тус өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, холбогдох ажил, арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Хас-Очир)-д үүрэг болгосугай.

3. Халдвар тархах эрсдэл бүхий нутагт нутаглаж буй малчидтай “Хариуцлагын гэрээ” байгуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Р.Гантулга), Мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Хас-Очир) нарт хариуцуулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642101125

Е/2022/Засаг дарга/Захирамж